



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 1/85

Мандалговь

Сургалт явуулах тухай

Монгол Улсын “Цэргийн албаны тухай хууль”-ийн 33 дугаар зүйл, “Дайчилгааны тухай хууль”-ийн 29 дүгээр зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 230 дугаар тогтоол, Батлан хамгаалахын сайдын 2017 оны н/03, ЗХЖШ-ын 2017 оны н/22 албан тоот, Батлан хамгаалахын сайдын аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний 3.5 дугаар зүйлүүдийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Цэргийн штабын “Үндсэн арга хэмжээний төлөвлөгөө”-нд тусгагдсаны дагуу ДБНБ-ний I зэргийн бэлтгэл үүрэгтэй 40 хүний сургалтыг Зэвсэгт хүчний 167 дугаар анги, Зэвсэгт хүчний 278 дугаар байгууламжийн сургалтын төвийн материаллаг баазыг түшиглэн 2017 оны 03 дүгээр сарын 26-наас 05 дугаар сарын 10-ны өдрүүдийн хооронд 10 хоногийн хугацаатайгаар явуулсугай.

Хоёр. Сургалтын зардалыг Батлан хамгаалах яамнаас төсөвлөсөн 4.375.000 төгрөгийг гарган хавсралтын дагуу зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга О.Чулуунбатад үүрэг болгосугай.

Гурав. Дээрх ДБНБ-ний нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтэн байлдагч, түрүүч нарын сургалтыг төлөвлөгдсөн хугацаанд чанартай, осол аваргүй явуулахыг Цэргийн штабын дарга, хурандаа Б.Амаржаргалд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ



620000203